



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 03 ДУГААР САРЫН 19-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 - 14

- 1. Түр хорооны тогтоолын төсөл /Нийслэлийн нийтийн тээврийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, парк шинэчлэх шаардлагын дагуу 2023 онд худалдан авсан автобусны худалдан авах ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий “Хянан шалгах түр хорооны даргыг сонгох тухай”/ 4 - 14*
-

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Хянан шалгах түр хороо /Нийслэлийн нийтийн тээврийн чанар, хүртээмжийг
нэмэгдүүлэх, парк шинэчлэх шаардлагын дагуу 2023 онд худалдан авсан автобусны
худалдан авах ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий/-ны
03 дугаар сарын 19-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 35 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, С.Одонтуяа;
Чөлөөтэй: П.Анужин.

Нэг.Түр хорооны тогтоолын төсөл /Хянан шалгах түр хорооны даргыг сонгох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, зөвлөх Я.Баасанбат, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Ч.Сарантуяа нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийг Хянан шалгах түр хорооны даргад нэр дэвшүүлэх саналыг гаргав.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Ж.Бат-Эрдэнэ, Т.Доржханд, Н.Ганибал нар үг хэлэв.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Нийслэлийн нийтийн тээврийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, парк шинэчлэх шаардлагын дагуу 2023 онд худалдан авсан автобусны худалдан авах үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий түр хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийг сонгох нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 1
Бүгд: 8
87.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн “Хянан шалгах түр хорооны даргыг сонгох тухай” түр хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: “Хянан шалгах түр хорооны даргыг сонгох тухай” түр хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 1
Бүгд: 8
87.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Түр хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 33 минут үргэлжилж, 11 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 72.7 хувийн ирцтэйгээр 13 цаг 08 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ
ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордны “Их засаг” танхим
12 цаг 35 минут

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг эрье.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 13 дугаар тогтоолоор Нийслэлийн нийтийн тээврийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, парк шинэчлэх шаардлагын дагуу 2023 онд автобусны худалдан авалтын манайхны яриад байгаа “Ногоон автобус”-ны худалдан авалтад хяналт шалгалт хийх Хянан шалгах түр хороо байгуулагдсан.

Ингээд Түр хорооны эхний хурлаар өнөөдөр бид Түр хорооны даргыг сонгох асуудлыг хэлэлцэхээр байгаа.

Тэгээд Түр хорооны ирц 11-ээс 7, 63.6 хувьтай, хангалттай байгаа учраас хуралдааныг нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн хуралдаанд ирсэн гишүүдийг танилцуулъя.

Хуралдаанд ирсэн Ж.Бат-Эрдэнэ, Х.Ганхуяг, миний бие, Г.Тэмүүлэн гишүүн, Ж.Чинбүрэн гишүүн, Ж.Батсуурь гишүүн, Т.Доржханд гэсэн гишүүд ирсэн байгааг мэдэгдье.

Мөн Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2024 оны 02 сарын 14-ний өдрийн 140 дүгээр

захирамжаар тус Хянан шалгах хорооны үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, зохион байгуулалтаар дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын алба бас байгуулагдсан байгаа.

Үүнийг бид ер нь Улсын Их Хурал анхааралдаа аваад нийт иргэдэд тодорхой ойлголтыг өгөх ёстой.

Тийм ч шаардлагаас энэ Түр хороо байгуулагдсан. Энэ худалдан авалтын үйл ажиллагаа нийгэмд ил тод болсноор цаашдаа иймэрхүү юу гэдэг юм, капитал засварын автобусууд орж ирэхгүй байх боломж хаагдсан.

Хэдийгээр яах вэ, эрх барьж байгаа хүчний хувьд хохиролтой асуудал боловч үүнийг шийдэж байгаа нь ирээдүйдээ хэрэгтэй.

Иргэд энэ дотор буруутгах улсууд нь мэдээж эрх барьж байгаа хүчний хүмүүс байгаа. Гэхдээ үүнийг нуухгүй ил гаргаснаараа цаашдаа ийм асуудал гарахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байгаа.

Ийм булай зүйл хийгдэхгүй байх хаалгыг нэг мөр хааж байгаа гэж ойлгож болно. Тэр агуулгаар энэ Түр хороо байгуулагдсан байгаа.

Ер нь ингэснээрээ цаашдаа тэр нүүрсний хэрэг, тэр Хөгжлийн банкны асуудал гэх мэтийн иймэрхүү зүйлүүд гарахгүй байх асуудлыг, хаалгыг нь хаах асуудлыг шийдэж байгаа гэдгийг би онцлон тэмдэглэхийг, хэлэхийг хүсэж байна.

Үүнийг янз бүрийн өнгөөр мэдээж сонгууль дөхсөн юм чинь улс төржүүлнэ, ярина. Гэхдээ энэ муу зүйл цаашдаа

үргэлжлүүлэхгүй байх үүднээс өнөөдөр энэ алхмууд хийгдэж байгаа шүү гэдгийг би хэлэхийг хүсэж байна.

Ингээд өнөөдрийн Түр хорооны хурлаар иргэдийн дунд **“Ногоон автобус”** гэдэг ийм бүр хэвшмэл хэллэг болчихсон энэ автобусны худалдан авалтын үйл ажиллагааг нийгэмд ил болгох үүрэг бүхий энэ ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг, тэр дотроо даргыг сонгох ийм хуралдаан хийгдэх юм.

Тэгээд би өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг би Та бүхэнд танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар Хянан шалгах түр хорооны даргыг сонгох асуудлыг хэлэлцэнэ. Нэг л асуудал байна.

Тэгээд энэ хэлэлцэх асуудалтай холбогдоод саналтай гишүүн байна уу? Өөрийгөө дэвшүүлэх хүн байна уу?

Миний бие болохгүй. Яагаад гэвэл Засгийн газартай холбоотой асуудал учраас ашиг сонирхлын зөрчил үүснэ.

Г.Тэмүүлэн гишүүн санал байгаа юм уу? Г.Тэмүүлэн гишүүн. Бүртгүүлчихсэн үү? Т.Доржханд гишүүн санал байгаа юм уу?

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж ярьж байгаа шүү дээ.

Г.Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Өнөөдөр ингээд Түр хорооны анхны хуралдаан болж байна.

Ингээд “Ногоон автобус” гэх тодотголтой хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явж дуусгаад шүүхэд шилжүүлсэн байгаа.

Үндсэндээ жил гаруй хугацаанд Монголын нийгмийг хамгийн их бухимдуулсан. Тэр дундаа цаашид Монголын төрд, тэр дундаа төсвийн хөрөнгөөр шамшигдуулсан нөхцөл байдал үүсэх ёсгүй гэдэг үндсэн дээр Улсын Их Хурлаас Түр хороог байгуулсан.

Ингээд үндсэндээ 7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдаж байгаа ажлын хэсэг шуурхай хугацаанд ажиллаж, олон нийтийг болоод Их Хурлыг бодит мэдээллээр хангах үүрэгтэйгээр байгуулагдлаа гэж харж байгаа.

Тэгээд бид бүхний ажлын хэсэг ч гэсэн асар хариуцлагатай, санаачилгатай ажиллах түүхэн үүрэг хүлээгдэж байна гэж харж байгаа.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэж байгаа гол үндсэн асуудал маань Түр хорооны даргыг сонгох асуудал байна.

Хувь хүнийхээ үүднээс миний хувьд Жадамбын Бат-Эрдгишүүнийг даргаар нэр дэвшүүлэх саналтай байна.

Нэгд, асуудал төсөв мөнгөтэй, төсвийн мөнгийг үрэн таран шамшигдуулсан, зориулалтын бусаар зарцуулсан, магадгүй бусдад давуу байдал бий болгож хахууль авсан гэх үндэслэл бүхий зүйл ангиар яллагдаж байгаа хэрэг байгаа.

Дээрээс нь энэ асуудал дээр бид мэргэжлийн талаасаа илүү авто тээврийн салбарт ажиллаж байсан дадлага туршлагатай, техникийн талаар тодорхой мэдлэг мэргэшилтэй хүнийг томилж, даргаар удирдуулж ажиллуулах нь зүйтэй байх.

Бид нарын хувьд тендерийн баримт бичигт заасан техникийн тодорхойлолт шаардлагыг хангаагүй гэх үндэслэл бүхий олон өмч хөрөнгийн асуудлууд энд дурдагдаж байгаа юм билээ.

Тэгэхээр энэ дээр ч гэсэн мэргэжлийн талаас оролцоод өөрийнхөө мэргэжлийнхээ талаас удирдаж чиглүүлээд явах дадлага туршлага нь ажлын хэсэгт Түр хороонд хэрэгтэй гэж үзсэний үндсэн дээр нэр дэвшүүлж байна. Жадамбын Ж.Бат-Эрдэнэ гишүүнийг.

Ц.Даваасүрэн: Шууд дараагийн асуудал орчихлоо шүү дээ.

Би хэлэлцэх асуудал дээр санал авсан байхгүй юу.

Хэлэлцэх асуудал дээр хүн бай байхгүй байсан байна. /алх цохив/

Ингээд нэр дэвшүүлэлтийн үйл ажиллагаа бол шууд эхэлчихлээ. Тэгээд нэр дэвшилэлт дээр Г.Тэмүүлэн гишүүн Ж.Бат-Эрдэнэ гишүүнийг санал болгосон байна.

Өөр саналтай гишүүн байна уу? Нэр дэвшилт дээр. Дарга дээр. Алга байна. Нэр дэвшилтийг хаалаа. /алх цохив/

Ингээд нэр дэвшигчдийн талаар санал хураалт явуулна. Тэгээд нэр дэвшигчээс асуулт асуух хүн байна уу? Тийм. Ногоон автобусны дарга шүү.

Ж.Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Гол нь би өнөөдөр хамгийн эхний ирцэд орсон. Тэгээд хүлээж байгаад сая орж ирлээ. Эхэнд байсан байх аа. Намайг орж ирэхэд.

Ц.Даваасүрэн: Чиний өмнө нэг хүн байсан шүү.

Ж.Батсуурь: Тийм үү? Хоёрт нь орж ирсэн.

Тэгээд та хэдийг зөндөө хүлээсэн байх нь байна шүү дээ. Тэгэхээр чинь 40 минут.

Үгүй ээ яах вэ, 2016 оноос хойш чинь мөн ч их юм боллоо доо. Тэгээд одоо ингээд бүгдээрээ л бид чинь тойрогтой хүмүүс. Хөдөө гадаа явж байна. Хүмүүсийн санаа сэтгэгдлийг сонсож байна.

Тэгээд нүүрсний хулгай, Хөгжлийн банк, ЖДҮ, тэгээд юу юу ч билээ дээ. Тэгээд энэ бол дандаа ужгирдаг, эзэн биет нь харагддаггүй, хариуцлага тооцогддоггүй. Тэгээд үүнээс болж нийгэмд асар их бухимдалтай. Иргэдийн төрд итгэх итгэл нэлээд суларчихсан. Ял зэм авч байгаа юм байхгүй. Хохирол нь төлөгдөж байгаа ч юм байхгүй.

Тэгээд л мөнгөний дүн бүр утгаа алдчихсан. Тэр их наяд гэдэг чинь ер нь саяхан яригддаггүй тоо байсан.

Тэгэхээр зөвхөн хулгайн л 40 их наяд. Тэрбум гэдэг тоо ч одоо ер нь мөн ч их тоо доо. Тэгээд л 300, 400, 500 тэрбумаараа л яригддаг.

Тэгэхээр олон хулгайнуудад бүгдийг биш юм аа гэхэд хамгийн түрүүлж цэг тавьчих боломж нь бол би энэ ногоон автобусыг гэж хараад байгаа юм. Яагаад вэ гэхээр эхэлсэн хугацаа нь маш ойрхон, бүх зүйл бодитоор цаасан дээр хараар байж байгаа.

Тэгээд Улсын Их Хурал захирамжаар ногоон автобусны чинь. Энэ

чинь Түр хороо билүү, Хяналт шалгалтын түр хороо билүү.

Тэгэхээр үүнийг бусад Түр хороо шиг ингээд ужгируулмааргүй байна. Ж.Бат-Эрдэнэ дарга аа. Тийм.

Ер нь ардчилсан нийгэмд намуудаар дамжиж л түр барина л даа. Сонгууль. Тэгтэл чинь намуудын чинь бүх нийлбэр итгэл нь ер нь нийгэмд бараг байхгүй болчихсон. Тэгээд үүнийг сэргээх, төрд итгэх итгэлийг бий болгох. Бүгдийг энэ хоёр, гурван сарын дотор амжихгүй л байх л даа.

Тэгээд үүнийг нэг ил гаргачих ганцхан боломжтой Түр хороо бол таны ахлах гэж байгаа Түр хороо л байна даа.

Тийм учраас бид нартай ямар дэмжлэг туслалцаа хэрэгтэй байдаг юм. Тэгээд аягүй эвгүй үед бий болж байна. Хүн болгон томсгосон тойрог руу, бүс рүү явна.

Тийм учраас өнөөдөр гэхэд л би бас ийм чухал асуудал юм чинь гэж бодоод л ирцдээ яг цагтаа ирсэн. Тэгээд завсраар нь хүмүүс цуглахгүй болохоор бас нэг ажил амжуулчхаад хүрээд ирлээ.

Тэгэхээр тал дээр л анхаармаар байгаа юм.

Тэгэхээр би том улс төрчдийн сүлжээ байж магадгүй гэж хардаж байгаа. Яагаад хардаж байна вэ гэхээр бүх хүн очоод үзээд энэ хуучин байна. Хуучин загварын автобус байна. Хуучин байна гэж ингэж бүх хүн үзээд хараад хэлээд байхад Монголын Үндэсний Радио Телевиз орон даяар шив шинэ байна гэж яриулж байгаа юм.

Дээр нь бүр ингээд тэнд ярилцлага өгүүлсэн хүмүүсийг судлаад үзэх юм бол

тэр нөгөө эзэд явуулсан байх магадлалтай байгаа байхгүй юу. Гэх мэтчилэн ингээд бүр эхэлсэн цаг, дууссан цаг, цаг минут, шилжсэн мөнгө. Эдгээр зүйлүүд нь тодорхой юмыг л Улсын Их Хурлын хяналт шалгалтын түр хороо, ногоон автобусны түр хороо шийдэж олон түмэнд цацаж чадахгүй л юм бол ер нь цаашид Улсын Их Хурлаас байгуулагдах түр хороонууд ч гэсэн нэг юм байгуулагдаж л байдаг юм. Тэгээд улс төрчдийг хамгаалаад, эрх баригчдыг хамгаалаад, авлигачдыг хамгаалаад дуусдаг юм гэсэн ийм зүйл рүү орчихгүй л гэж ингэж бодож байна л даа.

Тийм учраас намын зүгээс Н.Ганибал гишүүн, өөр манайхаас хэн байгаа юм бол. Бид байгаа юм байна. Тэгээд мэдээж олонхоороо явдаг. Тэгээд олонхоороо явна гэсэн агуулгаар үүнийг л нэг бүдгэрүүлээд дараад, тэгээд Зоригийн хэрэг шиг болгочих вий дээ.

Энэ чинь гучаад жилийн дараа одоо илрэх гэж байгаа гээд л эхэлдэг шиг ногоон автобусны хэрэг дараагийн Засгийн газрын, дараагийн Их Хурлын, дараа дараагийн улс төрчдийн тойрч мөлжиж иддэг ийм зүйл болгочихгүй л гэж ингэж санаа зовж байгаа юм.

Тэгээд энэ тал дээр л хэлж байна. Тэгээд асуулт, санал адилхан л гэсэн утгатай. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Ер нь Ж.Батсуурь гишүүн ээ, энэ ногоон автобус ч биш, өөрөөр хэлэх юм бол. Тийм.

Ер нь бол яах вэ өөрөө нөгөө Хөгжлийн банк, тэгээд бас нүүрсийг ярилаа шүү дээ. Би бол юу гэж ойлгож байна вэ гэвэл удаа харин Засаг, Ерөнхий сайд энэ дээр харин үүнийг ил байлгахын төлөө зогссон нь сайн тал.

Би жишээлбэл өнгөрсөн энэ арван хэдэн жилийн хугацаанд олон юман дээр шүүмжлэлтэй хандаж зогсож байсан. Гэтэл Засгийн газар дандаа нөгөө талд байсан.

Даже Оюу Толгой дээр бүр нөгөө талд байсан. Өнөөдөр бид Оюу Толгойгоос 5-хан хувийн борлуулалтын орлогоос ашиг хүртэж байгаа. Монгол. Гэтэл нөгөө талд үе үеийн Ерөнхий сайд, Ерөнхийлөгч нар байсан.

Одоо жишээлбэл тухайн үед миний дурдаж байсан зарим улсууд гээд тэгэхэд Хөгжлийн банкны хэрэг ингээд шүүх дээр ял авахад тэр холбогдсон улс төрийн албан тушаалтай улсууд бүгдээрээ мултраад үлдсэн.

Шүүх, Их Хурал хоёр ялгаатай, Засгийн газар ялгаатай.

Тийм учраас шүүхийн асуудлыг Их Хурал руу, Засгийн газар луу авчирч нь нялж болохгүй. Ил гаргаж тавьсан уу. Тавьсан. Хамгийн гол нь шүүх яллахдаа тэд нарыг үлдээсэн ийм юм гарсан гэдгийг бид ялгаж салгаж үзэх ёстой шүү. Тийм.

Тийм учраас би энэ асуудал дээр улс төржихгүйгээр. Ер нь би сонгууль руу хандуулж болохгүй. Үүнийг. Ер нь ил болгох ёстой.

Би түрүүн хэлсэн шүү дээ. Ямар ч гэсэн дахиад капитал засварын автобус авахгүй, хаалгыг хаасан гэж. Одоо ахиад хэн ч нүүрсний хулгай шиг юманд оролцож чадахгүй. Хэн ч тэр ЖДҮ рүү оролцож чадахгүй. Улс төрчид айгаад. Хэн ч өнөөдөр Хөгжлийн банкнаас очоод ахиад тэгж том зээл авч чадахгүй.

Тэгээд энэ хаалгыг нь хаагаад байгаа нь би сайн зүйл гэж харж байна.

Энэ удаа харин хэдийгээр намд хохиролтой ч гэлээ гэсэн Хөгжлийн банкны асуудлыг гаргаад л тавилаа. Манай намынхан холбогдлоо. Нүүрс дээр гаргаад л тавилаа. Манай намынхан холбогдлоо.

Тэгэхдээ тэрийг гаргаж тавьсан дээр хэн нэгнийг би хаацайлав гэж бодож байна. Бүгд гаргасан. Хамгийн гол нь шүүх дээр ял өгөхдөө асуудал гарсан.

Тийм учраас бид бодитой юман дээрээ бодитой хандаад, сайн юман дээр нь сайныг нь үнэлээд ингээд явах ёстой.

Түүнээс биш бүх зүйлийг иргэддээ бид харлуулж харагдуулах гэж чармайж болохгүй.

Ж.Бат-Эрдэнэ гишүүн. Нэр дэвшилттэй холбогдолтой шүү дээ.

Ж.Бат-Эрдэнэ: Хянан шалгах Түр хорооны даргаар миний бие нэр дэвшигдээд явж байна.

Тэгээд Ж.Батсуурь гишүүний хэлсэн санал бас хэдэн хариулт хэлье гэж бодож байна.

Ер нь Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль батлагдсан. Энэ хуулийн дагуу Хяналт шалгалтын түр хороо байгуулагдаж олон нийтэд мэдээлэл өгөх хуулийн дагуу ийм зарчимтай болсон шүү дээ.

Энэ бол маш том боломж. Өөрөөр хэлбэл элдэв янзын хулгай зэлгий хууль бус зүйлийг бид олон нийтэд мэдээлэлтэй болгож ирж байгаа. Олон нийтэд мэдээллийг нь өгч байгаа.

Урьд өмнө нь Хөгжлийн банкттай холбоотой түр хороо байгуулагдаад л сонсгол хийгдсэн. Араас нь нүүрсний сонсгол Та бүхэн бид бүгд бас л орж байгаад л ажилласан.

Тэгээд энэ бол ард иргэдэд маш том мэдээллийг өгч байгаа.

Тэгээд Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс зохион байгуулаад ногоон автобустай холбоотой түр хороо байгуулаад нийтийн сонсгол явуулья гэсэн ийм саналыг гаргаж ирсэн. Тийм үү. Энэ дээр миний бие гараа өргөөд гарын үсэг зураад дэмжсэн. Өөрөөр хэлбэл бид энэ хууль бус зүйлтэй аль аль талдаа дэмжээд байгаа шүү дээ. Дэмжээд тэмцээд байгаа.

Сая Ц.Даваасүрэн гишүүн хэллээ. Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Засгийн газрын тэргүүн, Монгол Ардын намын дарга, тэгээд Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнээс нэлээн том том асуудлуудыг өөрсдөө гаргаж ирж тавьж байгаа.

Өнөөдөр төр барьж байгаа, эрх барьж байгаагийн хувьд. Урьд өмнө ийм асуудлуудыг дардаг байсан шүү дээ. Энэ засгийн үед өөрсдөө энэ асуудлуудыг тавьж байгаа нь маш их сайшаалтай ийм зүйлүүд болж байгаа шүү дээ.

Тэгэхээр хуулийн дагуу Ардчилсан намын бүлгээс санаачлаад ногоон автобустай холбоотой асуудлуудыг олон түмэнд ил болгоё, нээлттэй сонсгол хийе гэсэн энэ саналыг бид бүхэн дэмжээд ингээд өнөөдөр энэ түр хороон дотор ороод ажиллаж байгаа.

Ямар ч байсан мэдээж олон түмэнд мэдээлэл өгөхийн тулд маш яаралтай ажиллах шаардлагатай. Хэрвээ сонгогдоод явах юм бол ганцхан би биш

шүү дээ бид бүхэн нэлээн идэвхтэй ажиллах ёстой байх гэж бодож байгаа. Ажиллана гэж бодож байгаа. Жишээлбэл Т.Доржханд гишүүнээс авхуулаад хэд хэдэн түр хороонд бид хамт ажилласан. Нээлттэй сонсгол хийсэн. Нэлээн туршлагатай гишүүд байж байгаа.

Тэгээд мэдээж Ардчилсан намын хувьд одоо энд чинь 4 гишүүн, 3 гишүүн орчихсон байгаа шүү дээ. Н.Ганибал гишүүн, Ж.Батсуурь, С.Одонтуяа, тэгээд ХҮН намаас Т.Доржханд гишүүн гээд.

Бид чинь зөвхөн нэг нам гэхгүй бас л сөрөг хүчнийхээ боломж бололцоог, үгээ хэлэх, хамтдаа шүүх, хамтдаа нээлттэй сонсгол хийх боломж бололцоог нээчихсэн байж байгаа. Энэ 4 сардаа. Ер нь тооцооллоор 4 сардаа багтаагаад түр хорооныхоо нээлттэй сонсголоо хийчих байх гэж төлөвлөж л харж байгаа даа. Тийм.

Тэгээд тэр утгаараа бүгдээрээ идэвхтэй ажиллаад мэдээж ард иргэддээ нээлттэй мэдээлэл өгөх бүхий л талаас нь.

Одоо Та бүхэн эмзэглээд, бас болгоомжлоод байх шиг байна. Мэдээж нууж дарагдуулах ч байдаг юм уу, цааш нь хууль бус зүйлийг ил гаргахгүй байх ч гэдэг юм уу, ийм зүйл байхгүй. Бид бүхэн хамтдаа бүхий л зүйл. Өөрөөр хэлбэл хаана хууль зөрчигдөж байгаа, хаана албан тушаалтан хууль зөрчсөн, энэ бүх зүйлийг нээлттэй гаргаж ажиллана аа л гэж бодож байгаа шүү. Тийм.

Ц.Даваасүрэн: Цаг хугацаа бол бага байгаа.

Санал аваад дуусчихсан шүү дээ. Хэлэлцэх асуудал дээр байсан байхгүй юу. Энэ жоохон дэггүй явчих гээд байна.

Хэлэлцэх асуудал байсан юм. Энэ чинь ийм юм байна. Хэлэлцэх асуудал дээр би үг авсан. Өөрөө яасан. Хэлэлцэх асуудал байна гэхээр больсон.

Дараагийнх нь нөгөө нэр дэвшилт байсан байхгүй юу. Үгүй ээ, үгүй. Дэггүй гэж би юуных нь дагуу л хэлж байна шүү дээ. Хурал даргалагчийн хувьд л хэлж байна шүү дээ.

Тэгэхдээ нэр дэвшигчтэй холбогдуулж би санал авсан чинь ганцхан Ж.Батсуурь гишүүн гараа өргөсөн байхгүй юу.

Тэгээд энэ чинь юу шүү дээ. Нөгөө нэр дэвшигчтэй холбогдуулж юм байна шүү дээ.

Ингэе. Хэдүүлээ бас дэгээрээ л явъя. Яагаад гэвэл сая би нэр дэвшигчтэй холбогдуулаад санал хэлэх гишүүн байна уу гэсэн байхгүй юу. Тэгсэн ганцхан Ж.Батсуурь гишүүн гараа өргөсөн.

Тэгээд яах вэ би хурал удирдаж байгаа учраас. Тэгээд манай хүн хариу өгсөн. Чи нэр дэвшигчтэй холбогдуулж тэгээд үг хэлэх гэж байгаа юм уу? Тэгвэл хэл хэл.

Нэр дэвшигчтэй холбогдуулаад Т.Доржханд гишүүнд үг өгчихье. Т.Доржханд гишүүнд үг өгчихье. Нэр дэвшигчтэй холбогдуулж.

Т.Доржханд: Баярлалаа. Нэр дэвшигчийгээ дэмжиж байна.

Тэгэхдээ зарчмын юу нь бол бид цаашдаа парламентын Түр хорооны даргыг сөрөг хүчнээсээ томилдог байх олон улсын жишгээ л барих ёстой юм билээ л дээ.

Тэгэхээр хуульдаа өөрчлөлт оруулах байдлаар явах нь зүйтэй л байх.

Ц.Даваасүрэн: Тэр бол зөв байх.

Т.Доржханд: Тэгээд хоёр зүйл байна. Нэр дэвшигчийн хувьд анхаарч ажиллах хоёр зүйл байна.

Тэр нь юу вэ гэхээр нийтийн тээврийн асуудал гээд зөвхөн “**цавчаа ногоон**” гэж яриад байгаа энэ цавчаа ногооны асуудлаас гадна түүнээс илүү ухаж үзэх ёстой юм нь болохоор энэ юу юм билээ шүү. Нийтийн тээврийн дотаци юм билээ.

Олон жил бугшаад явчихсан. Тэгээд хэн ч ордоггүй. Тэгээд л тэнд зүгээр ёстой битүү мөнгөний цавчаанууд явж байдаг.

Үүнийгээ дагаад тухайлбал дизелийн түлш гэхэд л энэ шинэ орж ирж байгаа автобусууд нь дандаа л нэг тийм хуучин дизель байдаг. Евро стандарт огт байдаггүй ч байдаг юм уу.

Ингээд л энэ дээр цэцэглэсэн бизнес пирамидуудыг бүгдээрээ нураах шаардлага байна гэж харж байгаа.

Тэгэхээр Түр хорооны даргын хувьд ийшээ илүү анхаарч үзээсэй гэж хүсэж байгаа юм. Бид нарын хувьд ч гэлээ гэсэн хамтарч ажиллахад бэлэн.

Хоёр дахь нь, Та бүхэн санаж байгаа бол Ардчилсан нам энэ түр хороо байгуулах санал гаргаад тэгээд бид дэмжээд. Би хамгийн түрүүнд гарын үсэг зураад л явсан гишүүний нэг л дээ. Тэрийг нь дэмжиж байгаа.

Гэхдээ ногоон автобусны асуудлыг чинь Нийслэлийн иргэдийн

Төлөөлөгчийн Хурал дээр ХҮН намын бүлэг гаргаж ирсэн байдаг.

Одоо энэ түр хороог бас ингээд хамтдаа эрх барьж байгаа намынхан удирдаад явуулна гэхээр энэ Улсын Их Хуралд суудалтай гурван намын хамтын ажил шүү. Тийм.

Түүнээс дахиад л манай Засгийн газар л үүнийг дэмжиж байгаа болохоор энэ асуудал явж байгаа гэсэн байдлаар явахгүй шүү. Тийм.

Тэгээд бүх асуудлын кредитийг эрх барьж байгаа нам л тэмцээд байдаг. Гэтэл Хөгжлийн банкны асуудлыг хэн гаргаж ирсэн юм, хэний бланк дээр явсан юм, нүүрс дээр хэн шүгэл үлээсэн юм.

Тэгээд энэ дээр ч гэсэн үр дүн чухал болохоос бид заавал нөгөө кредитийг нь булаацалдаад байгаа юм огт байхгүй. Гэхдээ энэ бол маш тов тодорхой, маш ойлгомжтой, богино хугацаанд бид үзээд дүгнэлтээ гаргах боломжтой ийм хулгайн асуудал.

Ийм хулгайн асуудал дээр манай ХҮН намын зүгээс тухайлбал Солонгост байдаг хууль хүчний байгууллага руу хандсан юм.

Прокурорын газар луу нь, цагдаагийн газар луу нь. Тэгээд бүгдээрээ нээлттэй хүлээж авсан. Гэхдээ хэрэг нээгээд явах гэхээр танай хуулийн байгууллагаас бичиг хэрэгтэй байна гээд гацаачихсан шүү.

Тэгээд энэ асуудлыг бид хуулийн байгууллагад тавьсан. Прокурор, цагдаагийн байгууллагад. Тэгээд хүртэл хэрэг нь нээгдэхгүй. Ингээд дарагдаад яваад байгаа шүү. Дарагдаад яваад байгаа.

Тэгээд Солонгосын талд үүнийг маш олон нийтийн байгууллага, бүр Үндэсний телевизээрээ хүртэл гаргаж явуулсан шүү дээ. Гэтэл манай Үндэсний телевиз нь болохоор үүнийгээ өмөөрөөд яриад яваад байдаг. Тэгээд нөгөө хоёр улсын соёлын ялгаа, дээрээс нь хандлагын ялгаа гарч ирж байгаа биз.

Тэгэхээр Засгийн газар үүнийг ил болохын төлөө дэмжиж явж байгаа гэж байгаа юм бол тэгвэл одоо тэр Засгийн газрын харьяа байгууллага, хууль хүчний байгууллагаасаа Солонгосын талд тэр албан бичгийг нь өгүүлмээр байгаа юм. Өгүүлээд тэнд хэрэг нээгээд энэ процессыг явуулмаар байгаа юм. Хоёр талдаа.

Нэгэнт ил болчихсон асуудал байхгүй юу.

Иймэрхүү байдлаар сонголт хийгдээд, тэгээд тэнд байгаа Солонгосын талын нөхдүүдийг авчирч байгаад, суулгаж байгаад ярих юм бол энэ үр дүнтэй болох байх.

Шаардлагатай гэвэл хууль, хүчний байгууллагууд нь, эсвэл тэндээс эрэн сурвалжилга хийж байгаа тэр сэтгүүлч нар нь хүрч ирээд мэдээллээ өгөөд явахад бэлэн юм байна гэдэг ийм ойлголттой байгаа шүү.

Тэгэхээр үр дүн гараасай гэж хүсэж байгаа. Тэгээд ХҮН намын хувьд бид энэ дээр аль болох иргэдийн мэдэх эрхийг хангах чиглэлээр өөрсдөө байгаа мэдээллээ өгөөд ил болгох чиглэлээр ажиллана гэсэн ийм байр суурьтай байна. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Н.Ганибал гишүүн. Та нар тэгээд би би гэхээ болиоч. Жижиг улс төр хийхээ боль л доо.

Н.Ганибал: Баярлалаа даргад. Процесс бол яах вэ.

Одоо өнөөдөр хамгийн гол нь байгуулагдаад, өнөөдөр даргатай болж байгаа нь яг Монголын ард түмний хүлээлтийн гол хариулт л даа.

Тэгээд яг түр хороо байгуулах процессын Ардчилсан намын бүлгээс санаачлаад гарын үсэг зуруулахад хамгийн гол нь 17 гишүүн гарын үсэг зурдаг. Тэгээд Монгол Ардын намын өнөөдөр эрх барьж байгаа намаас 10 орчим гишүүд гарын үсэг зурж байж өнөөдөр түр хороо албан ёсоор байгуулагдсан байхгүй юу.

Энэ нь л өөрөө энд орсон хүмүүс бүгдээрээ энэ асуултын хариултыг ард түмэндээ зөвөөр өгье.

Монголын төрд бугшаад байгаа энэ асуудал дээр бас зөв арга замыг нь олъё гэдэг ийм л түр хороо өнөөдөр байгуулагдсан гэж ойлгож байгаа.

Манай ХҮН намынхан шүгэл үлээгээд яг талбай дээр гараад анхныхаа ард түмнийг тэр үзүүлэх харуулах ажлыг хийсэн нь үнэн шүү дээ. Энд нуугаад байх юу байх вэ.

Ер нь манай түр хорооноос гарах хамгийн чухал хэд хэдэн асуудал байгаа. Мэдээж Эрүүгийн хянан шалгах энэ асуудлууд явж байгаа. Энэ бол процессын асуудал байх.

Энэ дээр гол гарч байгаа хоёр том хууль дээр бид зайлшгүй анализ хийж түүн дээр өөрчлөлт хийх, Их Хурлын гишүүдийнхээ хувиас бус хууль санаачлаад цааш нь явах ийм зайлшгүй хоёр хууль дээр ийм асуудал гарч байна уу даа гэж харагдаад байгаа юм.

Нэгд нь, Хувийн болон албаны нууцын тухай хууль байгаа. Яг энэ дээр Засгийн газар өнөөдөр байр суурь нь нууцад оруулсан уу, оруулаагүй гэдэг нь тодорхойгүй өнөөдрийг хүртэл явж байгаа. Үүнийг яг оруулсан юм уу, үгүй юм уу гэдгийг олон нийтэд ил болгомоор байна. Энэ бол төрийн ажил. Энэ бол ямар нэгэн мөрдөн байцаах асуудалд хамааралгүй асуудал.

Хоёрдугаар асуудал нь, Худалдан авах тендерийн тухай хууль дээр процессын ямар асуудлууд гарсан юм бэ? Шууд худалдан авалт хийхдээ Нууцын тухай хуультайгаа яг яаж холбоод байгаа юм? Энэ асуудал өнөөдрийг хүртэл хэн ч мэдэхгүй, хэн ч хариулахгүй яваад байгаа асуудал.

Энэ дээр ний нуугүй хэлэхэд Засгийн газрын яг хариуцсан сайд нар нь, Засгийн газрын гишүүд нь бас албан ёсны хариултыг өнөөдөр хүртэл өгөөгүй байгаа.

Тэгэхээр энэ бол бид нарын хувьд, энэ сонсголын үр дүнд яг энэ хуулиудын уялдаа, нууцад оруулж байгаад шууд худалдан авалт хийсэн тэр өмнөх олон оффтейк гэрээнүүдийн хамгийн төгсгөлийн ногоон автобус байгаа.

Тэгэхээр энэ дээр хэдүүлээ эцсийнх нь цэгийг нь тавиад, ийм асуудлууд дээр бид нууцад оруулж, гэрээ хийж, төрийн өмчийг шамшигдуулдаг ийм боломжийг бид таслан зогсоож ийм л бид нарын эцсийн үүрэг байх аа л гэж бодож байна. Баярлалаа.

Тэгээд нэр дэвшигчид амжилт хүсье.

Ц.Даваасүрэн: Нэр дэвшигчтэй холбогдуулаад асуулт асууж, санал хэлж дууслаа.

Би санал нэг байна. Энэ асуудлыг тэгээд нийтэд ил тод болгох ёстой. Бас эргэлзээтэй асуудлууд байсан учраас л мань мэт нь гарын үсэг зурсан байгаа шүү дээ. Тэгж л дэмжсэн байгаа шүү дээ.

Тийм учраас дээр хэдүүлээ нэг их улс төржихгүй ээ, би би гэж тодрохгүйгээр тэгээд бодит байдлыг нь ард түмэн чинь гаргаад өгчих хэрэгтэй.

Яагаад гэвэл миний нэг эргэлзээ төрөөд байгаа юм магадгүй тендерийн баримт бичиг дээр алдаа гаргасан байж магадгүй юм билээ шүү. Би Засгийн газрын хуралдаан дээр сонсож байхад жоохон гайхсан юм шүү.

Тийм учраас энэ бүх юмыг нь нэлээн яг иргэдэд нарийн гаргаж өгөөд ингэсэн байна, энэ одоо жишээлбэл нууцын горим дээр ийм алдаа гаргасан байна гээд зүгээр л Та бүхэн шударга л ажиллачих. Тэгээд л гаргаад өгчих.

Түүнээс биш би чи тэр гээд нэг их тодрох гээд энд хэрэг байхгүй гэж би бодож байна.

Одоо ингээд яг үндсэн ажилдаа орё. Би Ж.Бат-Эрдэнийг дэвшүүлсэн гээд унахгүй юм байгаа биз дээ. Ж.Бат-Эрдэнийг би дэвшүүлсэн шүү гээд байхгүйгээр хэдүүлээ ингэе.

Ингээд Г.Тэмүүлэн гишүүний гаргасан саналын дагуу Нийслэлийн нийтийн тээврийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, парк шинэчлэх шаардлагын дагуу 2023 онд худалдан авсан автобусны худалдан авах үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх Хянан шалгах түр хорооны даргад нэр дэвшигч Ж.Бат-Эрдэнийг дэмжье гэсэн саналын томъёолол санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

8-аас 7 гишүүн, 87.5 хувийн саналаар Ж.Бат-Эрдэнэ гишүүнийг түр хорооны даргаар томилохыг дэмжсэн байна. Санал дэмжигдлээ.

Одоо тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны тогтоол.

Дугаар 01.

Хянан шалгах түр хорооны даргыг сонгох тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэг, 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэг, “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17 өдрийн 13 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос ТОГТООХ нь:

1.Нийслэлийн нийтийн тээврийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, парк шинэчлэлийн шаардлагын дагуу 2023 онд худалдан авсан автобусны худалдан авах ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий түр хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийг сонгосугай.

2.Энэхүү тогтоолыг 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Хуралдааны даргалагч, Улсын Их Хурлын гишүүн гэсэн ийм тогтоол байна.

Тогтоолын төслийг дэмжье гэсэн саналын томъёоллоор. Санал байна уу? Санал асуух ёстой. Санал алга байна.

Тогтоолын төслийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулья. /алх цохив/

Тогтоолын төслийг 8-аас 7 гишүүн дэмжиж, 87.5 хувийн саналаар батлагдлаа.

Ингээд Нийслэлийн нийтийн тээврийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, парк шинэчлэх шаардлагын дагуу 2023 онд худалдан авсан автобусны худалдан авах ажиллагаанд хяналт шалгалт хийх Хянан шалгах түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналыг авч түр хорооны даргаар сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танд баяр хүргэж, ажлын амжилт хүсье.

Энэ хариуцлагатай ажлыг өндөр хариуцлагатай гүйцэтгэхийг хүсье. Таныг

Хуралдаан 33 минут үргэлжилж, 13 цаг 08 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД

хуралдаан даргалагчийн суудалд урьж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Түр хорооны даргаар итгэл хүлээлгэн сонгосон эрхэм гишүүддээ талархлаа илэрхийлье.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4-т Улсын Их Хурлын гишүүний өмнөх, эсхүл одоогийн үйл ажиллагаа нь тусгай шалгах тухай асуудалтай холбоотой бол уг гишүүнийг түр хорооны бүрэлдэхүүнд оруулахыг хориглоно гэж заасан.

Тиймээс гишүүд энэ талаар саналтай бол долоо хоногтоо багтааж түр хорооны даргад мэдээллээ ирүүлнэ үү гэсэн ийм саналыг Та бүхэнд хэлж байна.

Ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудал хэлэлцсэн тул хуралдааныг хаасныг мэдэгдье. /алх цохив/